ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБАНЫ 2019 ОНЫ 07 ДУГААР САРД
ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр | Улаанбаатар хот

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Тус алба нь Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газраас 2019 онд дэвшүүлсэн зорилт, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа.

Нийслэлийн хэмжээний 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангийн хурал, сахилга хариуцлагын зөвлөгөөнийг 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, албаны 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг “power point” программ дээр бэлтгэж алба хаагчдад танилцуулж, эхний хагас жилийн байдлаар бусдыгаа хошуучлан ажилласан алба хаагчдыг шангаж урамшууллаа.

Албаны даргын дэргэдэх зөвлөлийн 8 дугаар хуралдааныг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион явуулж 5 асуудал оруулж хэлэлцэж шийдвэрлэсэн. ЗУХ-ээс зөвлөлийн хуралд 40 нэгжийн 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний дүн, 2018 онд “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт хэлэлцүүлэгээс гаргасан 29 зөвлөмжийн хэрэгжилтийн явц байдал, үр дүнгийн тухай, Албаны дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийн хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай танилцуулгыг тус тус оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн Хэрэг бүртгэх тасгийн дарга нарын 14 хоног тутмын “Шуурхай зөвлөгөөн”-ийг 07 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж, хурлын тэмдэглэлээр хөтөлж албажуулсан.

Албаны 2019 оны 3 дугаар улирлын төлөвлөгөөнд оруулах саналыг нэгтгэн боловсруулж албаны 3 дугаар улирлын төлөвлөгөө, Захиргааны удирдлагын хэлтсийн 3 дугаар улирлын төлөвлөгөөг тус тус албаны даргад танилцуулж батлуулсан.

Албанаас 2019 оны эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн ажлын товч мэдээлэл, албаны даргаас тайлангийн хурал, сахилгын зөвлөгөөнд өгсөн үүрэг, алба хаагчдын байр эзэлсэн жагсаалтуудыг гаргаж нутаг дэвсгэр хариусан цагдаагийн байгууллагын дарга нарт 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 12а/883 дугаартай, ажлын товч мэдээг ЦЕГ-ын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын даргад 2019 оны 07 дугаар сарын 05-ны дөрийн 12/889 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэв.

Хэрэг бүртгэх албаны 2019 оны эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 07 дугаар сарын 01-ний өдрийн 12б/864 дугаартай албан бичгээр, Хэрэг бүртгэх албаны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг гаргаж 07 дугаар сарын 01-ний өдрийн 12б/865 дугаартай албан бичгээр, Цагдаагийн ерөнхий газрын 2019 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 07 дугаар сарын 05-ны өдрийн 12б/890 дугаартай албан бичгээр тус тус ЦЕГ-ын Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тус албанд хамаарах заалтын 2019 оны эхний хагас жилийн биелэлтийг гаргаж ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэст 06 дугаар сарын 25-ны өдрийн 12б/830 дугаартай албан бичгээр, Албаны дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2019 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэст 06 дугаар сарын 25-ны өдрийн 12б/832 дугаартай албан бичгээр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 2019 онд хэрэгжүүлэх дэд зөвлөлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст 06 дугаар сарын 25-ны өдрийн 12б/837 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/175 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг” ажиллах үүргийн хүрээнд албанаас хийж хэрэгжүүлсэн ажлыг биелэлтийг 06 дугаар сарын 20-ны өдрийн 12/808

дугаартай албан бичгээр, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Мөрдөн шалгах ажиллагааны мэргэжлийн зөвлөл, түүний үйл ажиллагааны чиглэл” /код 306/ -ын 306.1 дэх хэсэг, 306.2 дахь хэсгүүдэд “Хэрэг бүртгэх алба” гэсэн нэмэлт оруулах саналыг 07 дугаар сарын 16-ны өдрийн 12/906 дугаартай албан бичгээр тус тус Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын нэр дээр хүргүүлж ажиллаа.

Мөн тус албанаас 2019 оны эхний хагас жилийн байдлаар явуулсан дотоод хяналт шалгалт, алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, тоо мэдээг 06 дугаар сарын 21-ний өдрийн 12в/816 дугаартай албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст, Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Хууль зүй, дотоод хэргийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн биелэлтийг гарган 06 дугаар сарын 26-ны өдрийн 12в/841 дугаартай албан бичгээр Эрүүгийн цагдаагийн албанд тус тус хүргүүлж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газар болон харьяа албад, Нийслэлийн цагдаагийн газар, нэгжүүдээс нийт 75 хугацаатай болон хугацаагүй бичиг хүлээн авч, 26 хугацаатай бичиг ирсэний 15 албан бичгийн хариуг хугацаанд нь зохих газарт нь хүргүүлж, 11 албан бичгийн үлдэгдэлтэй байна. ЦЕГ, НЦГ болон албад, газар, хэлтэст нийт 77 албан бичигт боловсруулалт хийж хүргүүлэн, стандартын дагуу хэвлэн дугаар өгч бүртгэлийн дэвтэр тухай бүр хөтөлсөн. 2019 оны 07 дугаар сард Албаны даргын А тушаал 8, Б тушаал 5 гарсан, дугаар өгч хадгалалтыг ханган ажиллаж байна.

Хүний нөөц, сургалтын талаар:

Төрийн албанд мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, шатлан дэвшүүлэх зарчим, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх журам /код 900/”, “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах журам /код 908/”, “Албан тушаал дэвшүүлэх журам /код-909/”, ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн даргаас 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 5б/413, 08 дугаар сарын 24-ний өдөр 5б/485 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмж зэрэг Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаа.

“Аюулгүй ажлын байр” хэсэгчилсэн арга хэмжээний үр дүнгийн тухай танилцуулгыг ЦЕГ-ын ХМТ-д 12/863 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн “Аюулгүй ажлын байр” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд идэвхи зүтгэл гаргаж, бусдыгаа манлайлан, үр дүнтэй ажилласан алба хаагч нарыг шагнаж урамшуулах саналтай танилцуулгыг ЦЕГ-ын тэргүүн дэд даргад 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр 12/862 дугаараар хүргүүлсэн.

Тус албаны Дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтсийн “Мэдээлэл судалгаа хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн”-ий нэршил нь “Дүн шинжилгээ, мэдээлэл, судалгаа хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн” болгон өөрчилсөн тул нэршлийг өөрчлүүлэх “Дүн шинжилгээ, мэдээлэл судалгаа хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн”-ээр томилуулах саналтай холбогдох материалыг 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 12/874 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

ЦЕГ-ын Соён гэгээрүүлэх хэлтсээс 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдөр ирүүлсэн 5б/3776 дугаартай албан бичгийн дагуу E-hutuch.mn сайтаас 15 төрлийн богино хэмжээний шторк, 6 төрлийн богино хэмжээний киног татан авч албаны фейж хуудас веб сайтанд байршуулж сурталчилан ажилласан.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр

Тайлангийн хугацаанд Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн шинжтэй 7029 бүртгэгдсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад 716 нэгжээр буюу 10.1 хувиар өссөн байна. Нийт гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 2978 буюу 42.3 хувийг нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 44 буюу 0.6 хувийг нь харьяаллын дагуу бусад албадад шилжүүлэн, 3996 буюу 56.8 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж 7018 буюу 99.8 хувийг нь шийдвэрлэж одоо ажиллагаанд 135 гомдол мэдээлэл шалгагдаж байна.

Улсын хэмжээнд 20435 гэмт хэрэг бүртгэгдсэнээс “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” 4964 буюу нийт гэмт хэргийн 24.2 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 803 нэгжээр буюу 13.9 хувиар буурсан байна.

Нийслэлд 3181 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 550 нэгжээр буюу 14.7 хувиар, орон нутагт 1775 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 254 нэгжээр буюу 12.5 хувиар тус тус буурсан.

Улсын хэмжээнд 2019 оны эхний 07 сарын гэмт хэргийн илрүүлэлт 34.3 хувьтай, 2018 оны мөн үеэс 6.7 хувиар өссөн бол “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн илрүүлэлт **64.0** хувьтай, өмнөх оны мөн үеэс **11.9** хувиар өссөн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт нийслэлд 58.5 хувьтай, өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар, орон нутагт 75.7 хувьтай, өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар тус тус өссөн.

Улсын хэмжээнд 2019 оны эхний 07 сарын байдлаар /шинээр үүссэн болон харьяаллын дагуу хүлээн авсан/ хэрэг бүртгэлтийн 9145, мөрдөн байцаалтын 420, нийт 9565 гэмт хэрэг шалгаснаас 4410 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 2607 хэргийг хэрэг бүртгэлийн хэрэг хаах саналтай прокурорт шилжүүлж, 68 хэргийг харьяаллын дагуу бусад албадад шилжүүлэн, мөрдөн байцаалтаас 53 хэргийг хэрэгсэхгүй болгож, нийт 7138 хэрэг буюу 74.6 хувийг нь шийдвэрлэн, одоо ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 2502, үүнээс мөрдөн байцаалтын 173 хэрэг шалгагдаж байна.

Гэмт хэргийн улмаас 2514 иргэн хүнд, хөнгөн хохирч 4.731.781.347 төгрөгийн хохирол учирч нийт хохирлын 3.094.686.928 буюу 65.4 хувийг нь нөхөн төлүүлж, 55.8089.006 төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хохирогчийн эрх ашгийг хамгаалан ажилласан байна.

<u>Мэргэжил арга зүйн чиглэлээр:</u>

Албаны орон тооны бус “Мэргэжлийн зөвлөл”-ийн 8 дугаар хуралдааныг зохион байгуулж, хуралдаанаар харьяа нэгжүүдэд 2019 оны албаны хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтэд “Шалгасан хэрэг бүрийг 20 оноогоор тооцож байсныг хасч, шийдвэрлэсэн хэргийн харгалзах үзүүлэлтэд нийт шалгасан хэргийн тоог харгалзахаар, шүүх прокурорын буцалт бүрийг 3 оноогоор тооцож байсныг 5 оноогоор тооцож дүгнэх” өөрчлөлт орсонтой холбогдуулан албан бичиг боловсруулж 07 дугаар сарын 04-ний өдрийн 12а/884 дугаартай албан бичгээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Хэрэг бүртгэх тасгийн дарга нарт хүргүүлсэн. Мөн тус албаны харьяа нэгж, алба хаагчдын 2019 оны “Хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлт, тасаг, алба хаагчдын ажлыг дүгнэх” хүснэгт, аргачлалын дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 38 нэгж, нийт алба хаагчдын 2019 оны эхний хагас жилийн ажлыг цагдаагийн байгууллагын гэмт хэргийн нэгдсэн сангаар нэгтгэн дүгнэж, ажлын үзүүлэлтээр нь эрэмбэлэн хэлэлцүүлж ажиллаа.

Тус албанд шинээр мөрдөгчөөр томилогдсонтой холбогдуулан Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч нарын ажилтай танилцаж 21 хоногийн хугацаатай 124, 125 дугаартай зааварчилгыг газар дээр нь өгч, мөн Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Хэрэг бүртгэх тасагт шалгагдаж буй урьд оны дугаартай, ээдрээ төвөгтэй 8 хэрэгтэй танилцаж зааварчлан ажилласан.

Нэгжүүдийн 07 дугаар сарын 2 дахь долоо хоногийн мөрдөн шалгах ажлын мэдээгээр хэрэг бүртгэлтийн үлдэгдэл хэрэг өндөртэй байгаа Архангай, Баянхонгор, Дорноговь, Өвөрхангай, Сэлэнгэ аймаг, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтэс, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтэс, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Хэрэг бүртгэх тасгууд болон бусад нэгжийн тасгийн дарга, ахлах мөрдөгч нартай холбогдож хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг ахиулах талаар чиглэл өгч ажиллаж байна.

Хэлтсээс энэ оны эхний хагас жилд харьяа нэгжүүдэд хүргүүлсэн ажлын чиглэл, зөвлөмж, зааварчилга түүний биелэлт тооцсон дүнгийн талаар хавсралт хүснэгтийн дагуу гаргаж 07 дугаар сарын 02-ны өдөр Албаны дарга, дэд дарга нарт танилцуулсан. Энэ сард тус хэлтсээс удирдамжтай шалгалтын мөрөөр 2, ахлах мөрдөгч, мөрдөгчөөр шинээр томилогдсонтой холбогдуулан 3 буюу нийт 5 зааварчилгыг Сэлэнгэ аймаг, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Хэрэг бүртгэх тасгуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Хэрэг бүртгэх тасгийн алба хаагчдын энэ оны 07, 08 дугаар саруудад ээлжийн амралт эдлэх хуваарийг нэгтгэн Албаны даргад танилцуулан 4 заалттай ажлын чиглэл боловсруулж 06 дугаар сарын 20-ны өдрийн 12/809 дугаартай албан бичгээр харьяа нэгжийн тасгийн дарга нарт хүргүүлж ажиллаа.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 307.5.2/-д заасны дагуу шинээр оруулсан мэдээ мэдээлэл бүртгэгдээгүй, Emoirs.police.gov системд энэ сарын байдлаар 26 мэдээ мэдээлэл оруулсан байна.

<u>Дүн шинжилгээ, үнэлгээ, тоо бүртгэлийн чиглэлээр:</u>

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Хэрэг бүртгэх тасгийн дарга нартай өдөр тутам холбогдож хэргийн тоо, мэдээний талаар харилцан мэдээлэл солилцож, 7

хоногийн ажлын мэдээг 3 удаа нэгтгэж албаны удирдлагад танилцуулан нэгжүүдэд хүргүүлэн мэдээллээр хангаж ажилласан.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Хэрэг бүртгэх тасгийн энэ оны 07 дугаар сарын "Шийдвэрлэх хэргийн график"-т төлөвлөгөөнд оруулахаар ирүүлсэн нийт 559 хэргийн жагсаалтыг гарган 07 дугаар сарын 04-ний өдөр дэд даргаар батлуулж графикийн биелэлтийн явцыг 07 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар мэдээллийн сантай тулгалт хийж, нийслэлийн дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн Хэрэг бүртгэх тасгийн дарга нарын 14 хоног тутмын "Шуурхай зөвлөгөөн"-д танилцуулж, 08 дугаар сарын "Шийдвэрлэх хэргийн график"-ийн жагсаалтыг авч баталгаажуулав.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 38 тасгийн энэ оны эхний хагас жилийн мөрдөн шалгах ажлын мэдээ, албаны харьяа нэгжүүдийн 146 ахлах, мөрдөгч, мөрдөгчийн ажлын үзүүлэлтийг албаны энэ оны шалгуур үзүүлэлтийн дагуу тус тус нэгтгэж харьяа нэгжид дотоод сүлжээгээр мэдээллээр хүргүүллээ.

Албаны харьяа нэгжийн алба хаагчдын энэ оны 06 дугаар сарын хэргийн шийдвэрлэлт, нэг алба хаагчид ногдох ажил, ачааллын судалгааг тус бүрээр гарган албаны дэд даргад танилцуулсан.

"Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг"-ийн 2019 оны эхний хагас жил, 07 дугаар сарын "Инфографик"-ийг тус тус бэлтгэн албаны пэйж хуудас, фэйсбүүк группт байршуулав.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Хэрэг бүртгэх тасгуудын 2018 он, 2019 оны эхний хагас жилийн ажлын ачааллын мэдээг ирүүлсэн хүснэгтийн дагуу гаргаж Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст, энэ оны эхний хагас жилийн гэмт хэрэг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, нэг мөрдөгчид ногдох хэргийн ачаалал, нөхцөл байдлын хүснэгтэн мэдээг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд тус тус хүргүүлсэн.

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн 54 хэрэг Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст харьяаллаар шилжсэнтэй холбоотой нийт 54 хэргийг дүүргийн прокурорын газраас харьяалал тогтоосон жагсаалт, илтгэх хуудсын хамт ирүүлснийг хүлээн авч гэмт хэргийн сантай тулгалт хийсэн.

Хэрэг бүртгэх албаны нэгж, алба хаагчдын 2019 оны 07 дугаар сарын "Онцлох алба хаагч"-ийг цагдаагийн байгууллагын гэмт хэргийн санг үндэслэн яллагдагчаар татаж эрүүгийн хэрэг үүсгэсэн хэргийн жагсаалтаар эрэмбэлэн алба хаагчийн нэрийг шалгаруулсан саналыг албаны орон тооны бус "Мэргэжлийн зөвлөл"-өөр хэлэлцүүлж албаны даргаар баталгаажуулан ажиллаа.

Прокурорын байгууллагаас ирүүлсэн шаардлагыг мэдээллийн санд бүрэн бүртгэх үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Хан-уул дүүрэг дэх цагдаагийн 2-р хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Г.Тамир 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр MGL радиогоор "Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн түгээх худалдах борлуулах, түүнд хүлээлгэх хариуцлага" сэдвээр,

Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Энхсайхан 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдөр MGL радиогоор "Шаардлага хангахгүй барилгаас болж хүний эрүүл мэндэд хохирол учрах, Аюулгүй ажлын байр арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан ажлын талаар" сэдвээр тус тус иргэд олон нийтэд мэдээлэл хийж ажилласан.

Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журам зөрчсний улмаас хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Аюулгүй ажлын байр" арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан ажлын талаар 06 дугаар сарын 28-ны өдөр ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн төвийн байранд хэвлэлийн бага хурлыг хийж иргэд олон нийтэд сурталчилж, "Аюулгүй ажлын байр" арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан ажлын талаар богино хэмжээний видео шторк бэлтгэн 8 телевизүүдэд тараан ажилласан.

Албаны вэйб сайтанд эхний хагас жилийн товч мэдээлэл, тайлан зохион байгуулсан мэдээлэл, хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой мэдээлэл, нийт 5 мэдээллийг он сарын дараалаар оруулж, баяжуулалт хийсэн.

Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр сэдэвт сургалтын материалыг албаны фейж хуудсанд байршуулсан. Хэрэг бүртгэх албаны "Page" хуудасны дагагчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор ажил явуулж 4341 дагагчтай болгосон.

Хэрэг бүртгэх албаны “Page” хуудсанд 7 хоногийн хугацаанд урьдчилан сэргийлэх хэлтсээс болон албаны үйл ажиллагааг сурталчилсан 33 мэдээ, мэдээлэл хуваалцаж оруулсан нь давхардсан тоогоор 147936 иргэнд хүрсэн байна.

Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр:

Тус албаны энэ оны эхний хагас жилийн “Сахилга, ёс зүйн зөвлөгөөн”-д “Удирдах албан тушаалтны манлайлал, үүрэг хариуцлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлэхтэй холбоотойгоор бусдад туршлага болохуйц шинэлэг ажил, арга хэмжээ зохион байгуулж дүнг ирүүлэх талаар 07 дугаар сарын 07-ны өдрийн 12в/859 дугаартай албан бичгээр нийслэлийн дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн Хэрэг бүртгэх тасгийн дарга нарт хүргүүлэв.

Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээ, цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, мэргэжлийн ур чадварын талаар 500 гаруй иргэдээс авсан санал асуулгад дүгнэлт гаргуулахаар 12в/793 дугаартай албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст хүргүүлсэн.

Албаны даргын 2019 оны “Ажил эрчимжүүлэх тухай” 12в/52 дугаартай албан бичгээр хүргүүлсэн 01 дугаартай албан даалгаварын биелэлтийг харьяа нэгжүүдээс энэ оны эхний хагас жилийн байдлаар авч нэгтгэн гарган танилцуулсан.

Гурав: Бусад ажил

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.5-дах заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан үүргээ биелүүлж яваад амь эрсэдсэн алба хаагч нарынхаа гэгээн дурсгалыг хүндэтгэх, журамт нөхрөө эргэн дурсаж мөнхжүүлэх зорилгоор “Бид мартахгүй өдөрлөг” арга хэмжээг БЗД дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, БГД дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Төмөр зам дахь цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасагт ажиллаж байсан 3 алба хаагчдад албанаас 2 алба хаагч болон газар, хэлтсийн алба хаагч нартай хамтран хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр зохион явуулж, арга хэмжээний танилцуулгыг ЦЕГ-ын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэст 07 дугаар сарын 09-ний өдрийн 12б/896 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг болохтой холбогдуулж албаны даргын А/24 дүгээр тушаалаар байгуулагдсан комиссын бүрэлдэхүүн тус албаны архивт байгаа 2017, 2018 оны баримт бичгүүдийг тулгаж, зөрчил дутагдлыг засварлав.

Тулгар төр байгуулагдсаны 2228 жил, Их Монгол Улсын 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадмын “Соёолон” насны морины хамгаалалтад тус хэлтсийн алба хаагчид ЦЕГ-ын нэгдсэн хамгаалалтын төлөвлөгөө, зураглалын дагуу үүргээ хэвийн гүйцэтгэсэн болно.

ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА